

ЕБ-н Мөрөн “Гурван Эрдэнэ” сургууль

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2023.02.07

| | | |
|--|---|--|
| | <p>Нийлүүлэх барааны нэр</p> | <p><i>Нийлүүлэх бараа нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.</i></p> |
| | <p>Махан хоол, Yr tariq, Цагаан идээ</p> | <p>Бүтээгдэхүүн:</p> <ul style="list-style-type: none">➢ Монгол улсад мөрдөгдөж буй хүнсний эрүүл ахуйн тухай хуулинд нийцсэн, чанар стандартын шаардлага хангасан байх➢ Махан хоол нь чанарын шаардлага хангасан хонь үхрийн мах түлхүүр оруулсан байх➢ Төрөл бүрийн хоол амтлагач хийгээгүй, халуун ажиллагааны горим алдагдаагүй гүйцэт бололттой тос багатай➢ Төрөл бүрийн ногоо, баяжуулсан гурил, ислэг ихтэй хүнсний бүтээгдэхүүн оруулсан байх➢ Илчлэг нь 400 ккал-аас багагүй нэр төрөл олон 1,2-р хоол байх.➢ Yr tariаны холимог нь төрөл бүрийн шинэ ногоо, гурвалжин будаа, хөц будаа, шар будаа сүүтэй будаа, сүүтэйakash зэрэг хүүхдийн хүсэл сонирхолд нийцсэн, илчлэг амин дэмээр баялаг байх➢ Түгээх хоолны халуун нь 70-80 градус байх➢ Нэг удаа өгөх хоолны илчлэг 400 ккал-аас багагүй байх➢ Цагаан идээ нь Орон нутгийн малын сүүг ашиглан цэвэр сүүгээр боловсруулалт хийгдсэн хүнсний эрүүл ахуйн болон чанар стандартын шаардлага хангасан байх сүү орлуулагч өтгөрүүлэгч хэрэглээгүй байх➢ Өнгө оруулагч чихэр орлуулагч хийгээгүй байх➢ Амархан муудаж чанараа алддаг өндөг, майноз, крем ашиглаагүй байх➢ Жимсний төрөл бүрийн жүүс нь орон нутагт ургадаг жимс, жимсгэнээр хийсэн амт чанар сайтай, эрүүл ахуйн шаардлага хангасан төрөл бүрийн жүүс, жимсний салат➢ Байгалийн бус өтгөрүүлсэн сироп, өнгө оруулагч, чихэр орлуулагч ашиглаагүй байх.➢ Захиалагч байгууллагын зохиосон цэсний дагуу бүтээгдэхүүн нийлүүлэх |

Бусад:

- Олон хүүхдийн үдийн хоолыг нийлүүлэх хүчин чадалтай байх
- Нэг сурагчийн “Үдийн хоол” өдрийн 1500 төгрөгт багтсан байх
- Хүүхдийн насны онцлогт тохирсон илчлэг амин дэм, эрдэс бодисоор баялаг байх
- Өнгө үзэмж амт чанарын шаардлага хангасан байх
- Үйлдвэрлэсэн огноо, хэрэглэх хугацаа шаардлага хангасан байх

- Тээвэрлэлт, хадгалалт, хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байх
- Шаарлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх
- Нийлүүлэх бүтээгдэхүүний гарал үүслийг тендерийн бичиг баримтанд тусгаж өгсөн байх
- Амархан муудаж чанараа алддаг хүнсний бүтээгдэхүүнийг цэсэнд оруулж өгөхгүй байх
- Орон нутагт ургадаг жимс жимсгэний жүүс, цагаан идээ, баяжуулсан гурилаар хийсэн хүнсийг түлхүү оруулсан байх
- Кремьтэй бүтээгдэхүүн, төрөл бүрийн рулет, хавчуургатай бүтээгдэхүүн, зайдас, хиам, гамбургер, пицца, өндөг, хуурай өндөг, майноз, бүх төрлийн өтгөрүүлсэн сироп ашиглаж үйлдвэрлэсэн жүүс, шарсан төмс, тухайн орон нутагт үйлдвэрлээгүй сүү, сүүн бүтээгдэхүүн, чихрэлэг бүтээгдэхүүн, давсалсан самар, мөхөөлдөс, түргэн хоол, хийжүүлсэн ундаа зэргийг оруулахгүй байх
- Цэсэнд буй хүнсний бүтээгдэхүүнийг сард ноогдох давтамжийг 2-3 байхаар тооцох
- Үдиин цайг 7 хоног бүрийн Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан гариг бүр цагийн хуваарийн дагуу хоцролгүй нийлүүлж байх
- Дээжийг түгээлт хийх болгонд эмчид өгч эмч зөвшөөрсөн тохиолдолд сурагчдад түгээлт хийж байх
- Хүнсний шинэ бүтээгдэхүүнээр үйлчлэх, хадгалалтын хэмийг баримтлах нөхцлийг бүрдүүлсэн байх
- Гэрээт байгууллагаас үйдийн цайнд нийлүүлж буй бүтээгдэхүүнд дотоодын хяналтын явцад амт чанар, орцын хэмжээ алдагдахгүй байх
- Сургуулийн хүүхдийн үдийн цайны материал учир нийтийг хамарсан халдварт өвчин, хордлого зэрэг эрсдлээс дээд зэргээр сэргийлж ажиллах шаардлагатай.

Баглаа, боодол:

- ❖ Хүүхэд нэг бүрт тухайн бүтээгдэхүүн нэг бүрчлэн савалгаатай байх
- ❖ Үйлдвэрлэсэн огноо, сав баглаа боодлын стандарт шаардлага хангасан байх
- ❖ Хүнсний эрүүл аюулгүй байдлыг хангасан байх
- ❖ Стандартын шаардлага хангасан сав, боодол, шошготой байх
- ❖ Нэр хаяг үйлдвэрлэсэн он сар, өдөр, хадгалах хугацаа, үйлдвэрийн стандартын тэмдэглэгээтэй байх
- ❖ Хүүхдийн хоолыг хайрцаг сав баглаа боодолгүй ил задгай зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг хориглоно.

Ажлын хэсгийн ахлагч /*Б.Сүнжидмаа*/ Б.Сүнжидмаа

Гишүүд: бичиг хэргийн ажилтан /*Б.Дуламсүрэн*/ Б.Дуламсүрэн
 Сургуулийн нярав /*Л.Батчулуун*/ Л.Батчулуун
 Лаборант /*Б.Эрхэмбаяр*/ Б.Эрхэмбаяр
 Эцэг эхийн төлөөлөл /*Х.Пүрэвсайхан*/ Х.Пүрэвсайхан
 Эмч /*Б.Даваажаргал*/ Б.Даваажаргал